

МОНГОЛ УЛС  
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ  
БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ

**ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН**

(2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ)

|                                                                                                                                                            |    |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| <b>ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ</b> .....                                                                                                                              | 4  |
| Төслийн хөгжлийн зорилго .....                                                                                                                             | 4  |
| төслийн үр шим хүртэгчид .....                                                                                                                             | 4  |
| төслийн бүрэлдэхүүн хэсгүүд .....                                                                                                                          | 5  |
| <b>ТӨСЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛ</b> .....                                                                                                           | 5  |
| Төслийн удирдах хороо .....                                                                                                                                | 5  |
| Төслийн захирал.....                                                                                                                                       | 6  |
| Төсөл хэрэгжүүлэх нэгж .....                                                                                                                               | 6  |
| Төслийн хэрэгжилтийн зохион байгуулалт .....                                                                                                               | 6  |
| Төслийн үр дүнгийн хянах хүрээ .....                                                                                                                       | 6  |
| төслийн ач холбогдол .....                                                                                                                                 | 7  |
| <b>ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН</b> .....                                                                                                                | 8  |
| <b>БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ</b> .....                                                       | 9  |
| <b>Зорилт 1.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтэс (ХХҮГ/Х)-ийн үйлчилгээний зохион байгуулалт, арга хэрэгслүүдийг боловсронгуй болгох</b> ..... | 9  |
| 1.1.1. Үйлчлүүлэгч төвтэй ХЭҮ-ний ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх .....                                                                                     | 9  |
| <b>Зорилт 1.2. ХХҮЕГ-ын байр/танхимыг засварлах</b> .....                                                                                                  | 9  |
| 1.2.3. ХХҮЕГ-ын засварын ажил гүйцэтгэх, тавилга хэрэгслийг нийлүүлэх .....                                                                                | 9  |
| <b>Зорилт 1.3. ХЭҮ-ний ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, чадавх бэхжүүлэх</b> .....                                                   | 10 |
| 1.3.1.ХЭД тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаарх онлайн сургалтын модуль боловсруулах .....                                                 | 10 |
| 1.3.2. ХЭҮ-ний ажилтнуудын сургалтын материалыг видео хэлбэрт хөрвүүлэх .....                                                                              | 11 |
| 1.3.3. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээний мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах .....                    | 11 |
| <b>Зорилт 1.4. Хувийн хөдөлмөрийн биржтэй хамтран төрийн ХЭҮ-г сайжруулах</b> .....                                                                        | 12 |
| 1.4.1.Хувийн ХЭ-ийн байгууллагуудтай хамтран ажиллах загвар, санхүүжилтийн механизм боловсруулах .....                                                     | 12 |
| <b>БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЛЭГ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ТУРШИХ</b> .....                                                                        | 12 |
| <b>Зорилт 2.1. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх</b> .....                                                                              | 13 |
| 2.1.1. Бичил бизнес эрхлэгчдэд жижиг зээл олгох .....                                                                                                      | 14 |
| 2.1.2. Зээлийн өмнөх 2 өдрийн сургалт зохион байгуулах .....                                                                                               | 16 |
| 2.1.3. Зээлийн дараах санхүүгийн бүс үйлчилгээ үзүүлэх .....                                                                                               | 16 |
| 2.1.4. Санхүүгийн бүс үйлчилгээ үзүүлэх сургагч багш нарыг бэлтгэх, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах .....                                        | 16 |
| <b>Зорилт 2.2. Ур чадвар олгох шинэлэг хөтөлбөр хэрэгжүүлэх</b> .....                                                                                      | 17 |
| 2.2.1. Мэргэжлийн болон зөөлөн ур чадварын сургалтын гарын авлага, товхимол боловсруулах, хэвлэх, сургагч багш нарыг бэлтгэх .....                         | 19 |
| 2.2.2. Ажилгүй болон ажил хайгч иргэдэд хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа ур чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулах .....                        | 19 |
| 2.2.3. Мэргэшүүлэх сургалт зохион байгуулах .....                                                                                                          | 21 |

|                                                                                                                                     |           |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| 2.2.4. Иргэдийн өмнөх үр чадварыг хүлээг зөвшөөрөх үнэлгээ хийх, гэрчилгээжүүлэх ..                                                 | 22        |
| 2.2.5. Хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх .....                                                                                | 23        |
| <b>ЗОРИЛТ 2.3. "И-ЖОБ" ПЛАТФОРМЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ, БЭХЖҮҮЛЭХ .....</b>                                                                   | <b>24</b> |
| 2.3.1. И-ЖОБ платформыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх .....                                                                           | 24        |
| <b>БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МОНИТОРИНГ, ДҮН ШИНЖИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ, ТӨСЛИЙН УДИРДЛАГАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ .....</b> | <b>25</b> |
| <b>Зорилт 3.1. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээг сайжруулах .....</b>                                                | <b>25</b> |
| 3.1.2. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгаа хийх .....                                                                     | 25        |
| 3.1.3. Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөрт нөлөөллийн үнэлгээ хийх .....                                                      | 25        |
| 3.1.4. YAMAT-г шинэчлэх, YAMAT-08 системийг сайжруулах .....                                                                        | 26        |
| <b>Зорилт 3.2. Төслийн удирдлага, төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх .....</b>                                                     | <b>27</b> |
| 3.2.1. Төслийн хяналт, үнэлгээнд дэмжлэг үзүүлэх .....                                                                              | 27        |
| 3.2.2. Төслийг олон нийтэд таниулан сурталчлах .....                                                                                | 27        |
| 3.2.3. Төслийн удирдлагад дэмжлэг үзүүлэх .....                                                                                     | 28        |
| <b>БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 4 – КОВИД 19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЗОХИХ ШАЛГУУР ХАНГАСАН АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧДАД ТЭТГЭМЖ ОЛГОХ .....</b>         | <b>28</b> |
| <b>ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН .....</b>                                                                              | <b>29</b> |
| <b>ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН .....</b>                                                                               | <b>31</b> |
| <b>ДҮГНЭЛТ .....</b>                                                                                                                | <b>30</b> |

## ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ) Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” (ОБҮДХЭТ)-ийг 2020-2025 онд хэрэгжүүлж байна.

Төслийг 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Дэлхийн банкны захирлуудын зөвлөлөөр баталсан бөгөөд Монгол Улсын Засгийн газар болон Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн ассоциаци хооронд 2020 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан. Санхүүжилтийн хэлэлцээрийг 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр УИХ-аас соёрхон баталсан. Төслийг 2020 оны 11 дүгээр сарын 9-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. ОБҮДХЭТ нь ХНХЯ-аас 2018-2022 онд хэрэгжүүлсэн ‘Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл’ (ХЭДТ)-ийн дараагийн шатны төсөл юм.

### Хүснэгт 1. Төслийн мэдээлэл

|                           |                                                                                                                              |
|---------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Төслийн нэр               | Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл                                                                 |
| Хэрэгжүүлэгч байгууллага: | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам                                                                                   |
| Төслийн удирдагч          | Төслийн удирдагч: ДБ-ны Эдийн засагч Ян Хуан<br>Төслийн багийн гишүүн: ДБ-ны Нийгмийн салбарын ахлах мэргэжилтэн Н.Монголмаа |
| Төслийн захирал           | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Х.Тамир                                       |
| Төслийн зохицуулагч       | Төслийн зохицуулагч Ц.Байгалмаа                                                                                              |
| Төслийн өртөг             | 20.0 сая ам.доллар                                                                                                           |
| Санхүүжилтийн хэлбэр      | Олон Улсын Хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээл                                                                            |
| Төслийн хугацаа:          | 2020/11/09 – 2025/10/31                                                                                                      |

Дэлхийн банктай зөвшилцсөний дагуу төслийн хугацааг 2023 онд 12 сараар, 2024 онд 10 сараар сунгаж, 2025 оны 10 дугаар сарыг дуустал хугацаанд хэрэгжүүлж байна. Санхүүжилтийн хэлэлцээрт төслийн хугацаа сунгалт, бүрэлдэхүүн хэсгүүдийн санхүүжилтийн дахин хуваарилалтын холбогдох өөрчлөлтийг тусган, төслийн үр дүнгийн хянах хүрээ, шалгуур үзүүлэлт, хугацаа, хүрэх үр дүнг шинэчлэн баталсан.

### ТӨСЛИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

Төсөл нь ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлаас үүссэн хямралын үед зохих шалгуур хангасан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлд хөнгөлөлт үзүүлэх зорилготой.

Төслийн үйл ажиллагаа нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд тулгамдаж буй хөдөлмөрийн эрэлт, үр чадварын дутмаг байдал, сул ажлын байр болон хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийн талаарх мэдээллийн хомс байдал зэрэг хязгаарлалтыг арилгах, улмаар хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн.

### ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Төсөл нь хоёр бүлгийн үр шим хүртэгчтэй байна. Төслийн эхний үр шим хүртэгч бүлэг нь төслийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн холбогдох үйлчилгээ, дэмжлэгт хамрагдах хүн амын эмзэг бүлгийн ажил хайгч иргэн болон бичил бизнес эрхлэгч байна.

Хоёр дах үр шим хүртэгч бүлэг нь сонгогдсон аймаг, дүүргийн зохих шалгуур хангасан нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтөд тодорхой хугацаанд хамрагдах ажил олгогч болон түүний ажилтан байна.

Төслөөс жендэрийн тэгш оролцоог хангахыг зорьж, төслөөс хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд залуучууд, эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн иргэд, Казах хэлтэй үндэсний цөөнх иргэдийг тэгш хамруулахад анхаарч ажиллалаа.

---

## ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

ОБҮДХЭТ нь дараах 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэх;
2. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэх;
3. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон төслийн менежментийг сайжруулах;
4. КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан албан журмын даатгуулагчдад нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх болно.

Төслийн 1-3 дах бүрэлдэхүүн хэсгүүд нь хөдөлмөр эрхлэлтийн үр дүнг сайжруулахад чиглэсэн бол бүрэлдэхүүн хэсэг 4 нь КОВИД-19 цар тахлын үед нийгмийн даатгалд албан журмаар даатгуулсан ажилтнуудад богино хугацаанд тэтгэмж олгоход чиглэсэн.

Бүрэлдэхүүн хэсэг 1 нь үйлчлүүлэгч төвтэй төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжсэнээр мэдээллийн хомс байдал болон хөдөлмөрийн зах зээлийн ил тод байдал хязгаарлагдмал байдлаас үүдэлтэй ажил хайхад учирдаг хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн.

Бүрэлдэхүүн хэсэг 2 нь төслийн хүрээнд сонгосон хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлт хэрэгцээнд нийцсэн байдлыг сайжруулахад чиглэсэн.

Бүрэлдэхүүн хэсэг 3 нь хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээний чанар, хүртээмжийг сайжруулснаар байгууллагын болон хувь хэрэглэгчдэд хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлд үндэслэн зөв шийдвэр гаргахад туслах, хяналт-шинжилгээ үнэлгээ ба төслийн удирдлагыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн.

Бүрэлдэхүүн хэсэг 4 нь Ковид-19 цар тахлын үед албан журмын даатгуулагч ажилтнууд болон тэдний ажил олгогчдод түр хугацаанд тэтгэмж олгоход чиглэсэн.

## ТӨСЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

---

### ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРОО

ХНХ-ын сайдын 2021 оны А/149 дугаар тушаалаар 'ОБҮДХЭТ'-ийн Удирдах хороог байгуулсан. ТУХ нь төслийг ерөнхий удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөмж өгөх, төслийн үйл ажиллагаа, үйлчилгээ, худалдан авалтын төлөвлөгөө, төсөв батлах, зохицуулалтаар хангаж ажиллах чиг үүргийг гүйцэтгэж байна. ТУХ-г ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга ахлан удирддаг бөгөөд ГБХНХЯ-ны холбогдох хэлтсүүд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Сангийн яамны төлөөлөл бүхий 8 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

---

## ТӨСЛИЙН ЗАХИРАЛ

ГБХНХЯ-ны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга нь төслийн захирлын үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Төслийн захирал нь ТУХ-ноос гаргасан стратеги чиглэлийн дагуу төслийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, ТХН-ээр дамжуулан төслийн хэрэгжилтийг хариуцаж ажиллана.

---

## ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-ийн бүтэц, орон тоог Сангийн сайдын 2022 оны 281 дүгээр тушаалаар баталсан. ТХН нь төслийн зохицуулагч, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөрийн зах зээл хариуцсан ажилтан, санхүүгийн ажилтан, худалдан авалтын ажилтан, хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан, төслийн орчуулагч-нарийн бичиг болон жолооч гэсэн бүрэлдэхүүнтэй.

ТХН нь төслийн өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах, төслийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрд тусгагдсан үйл ажиллагаа, зөвлөх үйлчилгээ, сургалт, судалгаа, худалдан авалтын үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэл, тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээний хяналтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

---

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ГБХНХЯ нь төслийг өөрийн холбогдох харьяа байгууллагууд болох Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ), орон нутгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс (ХХҮГ/Х), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт (ХНХСҮСИ) болон Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ)-аар дамжуулан ТХН-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүллээ. Тодруулбал, ГБХНХЯ-ны харьяа агентлаг, хэлтсүүд дараах байдлаар оролцоно.

- 1) ХХҮЕГ нь 1 бүрэлдэхүүн болон 2.1 дэд бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэх үүрэгтэй;
- 2) Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд нь 1 бүрэлдэхүүн хэсэг болон 2.1 дэд бүрэлдэхүүн хэсгийг анхан шатанд хэрэгжүүлэхэд оролцоно;
- 3) ХНХСҮСИ нь ТХН-тэй хамтран 2.2 болон 3.1 дэд бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэхэд оролцоно;
- 4) НДЕГ нь 4 дүгээр бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

ТХН нь төслийн бүх бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд ялангуяа 1 ба 3 дугаар бүрэлдэхүүн хэсэг болон 2.1 ба 2.2 дэд бүрэлдэхүүн хэсэгт түлхүү оролцсоо. ТХН нь бүх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд чадавхыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээ хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хэрэгжүүлсэн.

---

## ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ХЯНАХ ХҮРЭЭ

Төслийн үр дүнг төслийн хөгжлийн 6 зорилго (ТХЗ), дунд хугацааны үр дүнгийн 12 шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүд :

(a) Ажлын зуучлалын үйлчилгээ:

- Шинэчилсэн ХХҮГ/Х-ээс ажил зуучлалын үйлчилгээ авсан үр шим хүртэгчдийн тоо
- Шинэчилсэн ХХҮГ/Х-ээс ажил зуучлалын үйлчилгээ авсан эмэгтэй үр шим хүртэгчдийн тоо

(b) Нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн дэмжлэг:

- НДШ-ийн хөнгөлөлтийн дэмжлэгт хамрагдсан үр шим хүртэгчдийн тоо

- НДШ-ийн хөнгөлөлтийн дэмжлэгт хамрагдсан эмэгтэй үр шим хүртэгчдийн тоо

(с) Бичил бизнес эрхлэгчдэд үзүүлсэн дэмжлэг:

- Бичил зээл авсны дараа 6 сараас дээш хугацаанд үйл ажиллагаагаа тогтвортой эрхэлж байгаа үр шим хүртэгчдийн хувь
- Бичил зээл авсны дараа 6 сараас дээш хугацаанд үйл ажиллагаагаа тогтвортой эрхэлж байгаа эмэгтэй үр шим хүртэгчдийн хувь.

---

## ТӨСЛИЙН ХҮРСЭН ГОЛ ҮР ДҮН БА АЧ ХОЛБОГДОЛ

**Төслийн хүрээнд И-Жоб платформын сайжруулалтад үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлж, хэрэглэгчдийг шаардлагатай компьютер, тоног төхөөрөмжөөр ханган, сургалтад хамруулснаар ажилтнуудын чадавхыг бэхжүүлээ.** Төслөөс 2022 онд И-Жоб платформын серверийн программ хангамж, лиценз болон тоног төхөөрөмжийг 474.2 сая төгрөгөөр худалдан авч нийлүүлсэн. Мөн хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний нийт 657 ажилтнуудыг И-Жоб платформын хэрэглэгчийн 3 шатны сургалтад хамруулж, чадавхыг бэхжүүлсэн. И-Жоб платформын баталгаат 18 сарын хугацаанд системийг нэвтрүүлэх явцад гарсан алдааг засварлан, засвар үйлчилгээ, нэмэлт сайжруулалт хийж, 2024 оны 6 сард платформыг хүлээж авахад дэмжлэг үзүүлэв. Түүнчлэн И-Жоб платформыг дэмжиж ажиллах хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэрэглэгчдэд нийт 2.55 тэрбум төгрөгийн 905 компьютер, тоног төхөөрөмж нийлүүлсэн. 2025 онд хөдөлмөр эрхлэлтийн /ажил мэргэжлийн чиг баримжаа, ажил зуучлал/ суурь үр чадвар олгох 45 сургалтын модуль хөтөлбөр, видео хичээлийг боловсруулан хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний нийт 165 ажилтныг цахим сургалтад хамруулж, чадавхыг бэхжүүлээ. Эдгээр үйл ажиллагаа нь ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Цахим үндэстэн болох зорилтыг хангах, “Үйлчлүүлэгч төвтэй” үйлчилгээний орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсан. ГБХНХЯ, ХХҮЕГ, аймаг, дүүргийн ХХҮГ/Х-үүдийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлснээр системийг цаашид бие даан удирдах, дунд болон урт хугацаанд системийн тогтвортой байдлыг хангах боломжийг бүрдүүллээ.

**Төслийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдэд бичил зээл олгох, санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг олгох арга хэмжээг 2024-2025 онд хэрэгжүүлж байна.** Бизнесээ өргөжүүлэх, ажлын байр бий болгох, хадгалахад нь зориулж, 21 аймаг, 9 дүүргийн нийт 610 бичил бизнес эрхлэгчдэд 15.3 тэрбум төгрөгийн жижиг зээлийг олгоод байна. Зээлийн арга хэмжээний дүнд 1,655 ажлын байрыг дэмжсэн бөгөөд үүнээс 1,119 ажлын байрыг хадгалж, 536 ажлын байрыг шинээр бий болгов. Түүнчлэн зээлийн өмнөх сургалтад 21 аймгийн 858, мөн 9 дүүргийн 1,575, улсын хэмжээнд нийт 2,433 бичил бизнес эрхлэгчийг хамруулсан байна. Жижиг зээлийн эргэн төлөлтөөс 2.3 тэрбум төгрөгийг дахин эргэлтэд оруулж, зээл олголтод ашигласан байна. Зээлийн дараах сургалтын агуулга хөтөлбөрийг сайжруулж, санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх 41 сургагч багш бэлтгэв. 2025 онд зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг орон нутагт зохион байгуулж байна. Төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ нь ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих зорилтыг биелүүлэхэд шууд хувь нэмэр орууллаа.

**Төслийн хүрээнд “Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй 17 мэргэжлийн хүрээнд 1,225 иргэний үр чадварыг дээшлүүлэв.** Уг хөтөлбөрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт 2024-2025

онд хэрэгжүүлж байгаа бөгөөд мэргэжлийн үр чадвар олгох сургалтад 725 хүн, мэргэшүүлэх сургалтад 300, иргэний өмнөх мэдлэг үр чадварыг хүлээн зөвшөөрөх (RPL) үнэлгээнд 200 иргэнийг хамруулсан. 2025 онд мэргэжлийн үр чадвар эзэмших хүсэлтэй ажилгүй иргэд, ажил олоход хүндрэлтэй байгаа иргэдийг дэмжих стандарт үйлчилгээг улсын хэмжээнд үргэлжлүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс батлан хэрэгжүүлж байна. Энэ нь төслийн нэвтрүүлсэн шинэлэг үйлчилгээ, аргачлал хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний салшгүй хэсэг болж байгааг харуулж байна.

**Төслөөс салбарын мэдээллийн нэгдсэн сан, системүүд, их өгөгдлийг үе шаттайгаар үүлэн дэд бүтэц рүү шилжүүлэх ажилд дэмжлэг үзүүлж байна.** Төсөл нь 2025 онд их өгөгдөлд суурилсан мэдээллийн системд зориулсан сервер, хадгалах төхөөрөмж, сүлжээний төхөөрөмж болон програм хангамжийн лицензүүд (үүлэн дэд бүтэц байгуулах) худалдан авах 1 үйл ажиллагааг хэрэгжүүлж, гэрээ байгуулах шатандаа байна. Үүний үр дүнд салбарын мэдээллийг нэгтгэн цэгцэлж, найдвартай хадгалах, өгөгдлийг үр дүнтэй боловсруулах дэвшилтэт системийг бий болгож, төрөөс харилцан уялдаатай цогц бодлогыг үр дүнтэй, хэрэгжүүлэх боломж бүрдэн иргэдийн амьдралын чанарт бодитой эерэг нөлөөг бий болгоно.

**Хөдөлмөрийн зах зээлийн (ХЗЗ) мэдээлэл, дүн шинжилгээний хүрээ, хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх зорилгоор судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлуудыг амжилттай гүйцэтгэсэн.** ХНХСИ ХЗЗ-ийн эрэлтийн 2022 оны Барометрийн судалгаанд Ур чадварын эрэлтийн нэмэлт модуль судалгааг боловсруулан гүйцэтгэж, үр дүнг бодлого боловсруулагчид, хэрэглэгчдэд түгээсэн. Төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа “Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр”-ийн үнэлгээний арга зүйг шинээр туршин амжилттай хэрэгжүүллээ. Мөн албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгааг гүйцэтгэсэн. YAMAT-08-ыг шинэчлэх ажлын хүрээнд нийт 165 ажил, мэргэжлийн профайлыг боловсруулж, ГБХНХ-ын Сайдын 2025 оны А/79 тушаалаар 100 ажил мэргэжлийн лавлахыг YAMAT-08-д нэмж батлуулсан. Түүнчлэн YAMAT-08-ын цахим системийн засвар, хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэсэн. Судалгаа, үнэлгээний ажлын дүнд хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн чанар, хүртээмж сайжирч, бодлого боловсруулагчид, судлаачдын чадавх бэхжин цаашид судалгаанд суурилсан бодлого төлөвлөлтийн тогтолцоог төлөвшүүлэхэд хувь нэмэр орууллаа. Төслийн удирдлага, зохион байгуулалтын дүнд бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн үр дүн дээшилж, төслийн хөгжлийн зорилтыг хангахад хувь нэмрээ оруулсан.

**Төслөөс 28.5 тэрбум төгрөгийн (10.0 сая.ам.дол) тэтгэмжийг зохих шалгуур хангасан ажиллагчдын нийгмийн даатгалын шимтгэл (НДШ)-ийн хөнгөлөлтийн дэмжлэгт олгосон..** Энэ арга хэмжээнд албан журмын даатгалд хамрагдсан 152,475 ажиллагчид болон 18,598 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг нэг сарын хугацаанд чөлөөлсөн бөгөөд үр шим хүртэгчдийн 47.2% (71,894)-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Ажиллагчид болон ажил олгогчдын НДШ-ийг түр хугацаанд чөлөөлж, тэтгэмж олгосон нь онцгой байдлын үед нийгмийн даатгалын санд үүсэх санхүүгийн дарамтыг бууруулахад дэмжлэг болсон.

## ТӨСЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төслийн Удирдах хорооны хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Сангийн яамнаас 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/10803 тоот дугаартай албан бичгээр ГБХНХЯ-д тус салбарт гадаад зээлийн хөрөнгөөр

хэрэгжиж буй төслүүдийн 2025 оны санхүүжилтийг түр хойшлуулахтай холбоотой ажлын жагсаалтыг ирүүлсэн. Уг шийдвэрийн хүрээнд СЯ төслийн 37 арга хэмжээг хойшлуулж, 19 арга хэмжээний 6.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг баталсан. Батлагдсан төсвийн хүрээнд төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 84%-ийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгтээр харуулбал:

| Хэрэгжилтийн хувь       |                    | Хүлээгдэж байгаа | 40% | 50% | 70% | 90% | 100% | Нийт оноо | Дүн |
|-------------------------|--------------------|------------------|-----|-----|-----|-----|------|-----------|-----|
| Арга хэмжээний тоо – 57 | Төсөв баталсан -19 | 2                | 1   | 1   | 5   | 2   | 8    | 17        |     |
|                         | Хойшлуулсан - 37   | -                | 40  | 50  | 350 | 180 | 800  | 1,420     | 84% |

## БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ

**Зорилго:** Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэх

**Үр шим хүртэгч:** Төслийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдах ажил хайгч иргэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн дагуу “ажил хайгч”-ийг дараах хоёр ангиллын нэгт хамаарах иргэдээр тодорхойлсон. Үүнд: (а) ажилгүй иргэд болон (b) ажилтай боловч шинээр ажил хайж байгаа иргэд орно. Түүнчлэн төслийн үйл ажиллагаа нь хүн амын эмзэг бүлгийн тухайлбал, 18–34 насны залуучууд, ажил олоход хүндрэлтэй иргэдэд чиглэнэ.

**Зарцуулалт:** Тайлант хугацаанд бүрэлдэхүүн хэсэг 1-ийн 3 зөвлөх үйлчилгээний гэрээний төлбөрт 129.0 сая төгрөгийн санхүүжилт, мөн олон улсын хурал чуулганы томилолтын зардалд 299.4 сая төгрөг, нийт 428.4 сая төгрөгийг зарцуулсан.

### ЗОРИЛТ 1.1. ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР/ХЭЛТЭС (ХХҮГ/Х)-ИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРГА ХЭРЭГСЛҮҮДИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

#### 1.1.1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ХЭҮ-НИЙ АЖИЛТНУУДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

2025 онд ХХҮЕГ-тай хамтран хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний нийт 165 ажилтныг хөдөлмөр эрхлэлтийн /ажил мэргэжлийн чиг баримжаа, ажил зуучлал/ суурь үр чадвар олгох цахим сургалтад хамруулж, чадавхыг бэхжүүлэв.

### ЗОРИЛТ 1.2. ХХҮЕГ-ЫН БАЙР/ТАНХИМЫГ ЗАСВАРЛАХ

#### 1.2.3. ХХҮЕГ-ЫН ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ КОМПАНИТАЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ТАВИЛГА ХЭРЭГСЛИЙГ НИЙЛҮҮЛЭХ

ХХҮЕГ-ын засварын ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах MERESP C1-CW-2023-2-1; ТХААЦСистем: ОБУДХЭТ/20240801005 дугаартай тендерийг 2024 оны 4 сард зарласан. Үнэлгээний хороо засварын ажил гүйцэтгэгчээр “Мандалт констракшн” ХХК-г 2024 оны 12 сард сонгон шалгаруулсан. “Мандалт констракшн” ХХК-тай гэрээ байгуулах явцад Сангийн яамнаас 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/10803 тоот дугаартай албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус салбарт гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн 2025 оны санхүүжилтийг түр хойшлуулахтай холбоотой ажлын жагсаалтыг ирүүлсэн.

ХХҮЕГ-ын засварын ажил уг жагсаалтад орсон тул санхүүжилт хойшлогдон удааширч, товлосон хугацаанд багтаан гүйцэтгэх боломжгүй болсон тул цуцлагдсан.

### **ЗОРИЛТ 1.3. ХЭҮ-НИЙ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ, ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ**

Түс дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд салбарын ажилтнуудын мэдлэг, үр чадварыг сайжруулах хүрээнд нийт 45 сургалтын модуль хөтөлбөр, видео хичээлийг боловсруулан ХХҮЕГ-ын онлайн сургалтын платформд байршуулж, ГБХНХЯ, төслийн вэбсайтаар олон нийтэд хүргэж байна. Салбарын ажилтнуудын мэдлэг, үр чадварыг сайжруулах хүрээнд дараах сургалтын хөтөлбөр, видео хичээлийг боловсруулан ашиглалтад оруулсан:

- (1) Хөдөлмөр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаарх 4 багц, нийт 26 сургалтын модуль ба видео хичээлүүд,
- (2) Үндэсний Ажил Мэргэжлийн Ангилал, Тодорхойлолтын (YAMAT-08) тухай хичээлүүд,
- (3) Салбарын мэргэжилтний үр чадварын багц 11 сэдэв хичээлүүд,
- (4) Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зүүчлэх үйлчилгээний мэргэшсэн зөвлөхийн суурь үр чадвар олгох сургалтын 4 модуль ба ахисан түвшний сургалтын 4 модуль хичээл.

Мөн олон улсын форум болон шилдэг туршлагатай танилцуулах сургалтаар дамжуулан төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. 2025 онд Швейцарын Холбооны Улсын Женев хотод зохион байгуулсан Олон Улсын Хөдөлмөрийн Бага хурлын ээлжит 113 дүгээр чуулганд ГБХНХЯ-ны удирдах ажилтнуудыг оролцуулах томилолтын зардал болон АНУ-ын Вашингтон хотод зохион байгуулсан Дэлхийн банкны 2025 оны хаврын чуулга уулзалтад оролцсон төлөөлөгчдийн томилолтын зардлыг төслөөс олгосон.

#### **1.3.1.ХЭД ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ХОЛБОГДОХ ДҮРЭМ, ЖУРМЫН ТАЛААРХ ОНЛАЙН СУРГАЛТЫН МОДУЛЬ БОЛОВСРУУЛАХ**


Хөдөлмөр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаарх онлайн сургалтын модуль боловсруулах ажлыг хэрэгжүүлэхээр "Мэдлэгийн хотхон" НҮТББ 2024 оны 6 сард гэрээ байгуулсан. Энэ ажлын хүрээнд салбарын ажилтнуудад зориулан 4 багц, нийт 26 онлайн сургалтын модулийн слайд болон видео хичээлийг боловсруулсан.





### 1.3.2. ХЭҮ-НИЙ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН МАТЕРИАЛЫГ ВИДЕО ХЭЛБЭРТ ХӨРВҮҮЛЭХ

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудад зориулсан сургалтын материалыг видео хэлбэрт хөрвүүлэх ажлыг гүйцэтгүүлэхээр "Майнд Вайд" ХХК-тай 2024 оны 9 сард гэрээ байгуулсан. "Майнд Вайд" ХХК нь YAMAT-08-ын хичээлүүд болон хөдөлмөр эрхлэхэд шаардагдах үр чадварын сургалтын материалыг видео хэлбэрт оруулж, цахим сургалтад ашиглах боломжийг бүрдүүлсэн.



### 1.3.3. АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ, АЖИЛД ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХ

“Ажил мэргэжил судлалын үндэсний хүрээлэн” НҮТББ 2024 онд байгуулсан гэрээний дагуу ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээний мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсрууллаа. Үүнд суурь үр чадвар олгох 15 академик цагийн 4 модуль хичээл болон ахисан түвшний 45 академик цагийн 4 модуль хичээл, багшийн гарын авлага, презентац багтаж байна. Мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтын хөтөлбөрийг ХХҮЕГ-ын даргын 2025 оны А/186 дугаар тушаалаар баталсан.



## ЗОРИЛТ 1.4. ХУВИЙН ХӨДӨЛМӨРИЙН БИРЖТЭЙ ХАМТРАН ТӨРИЙН ХЭҮ-Г САЙЖРУУЛАХ

### 1.4.1. ХУВИЙН ХЭ-ИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЗАГВАР, САНХҮҮЖИЛТИЙН МЕХАНИЗМ БОЛОВСРУУЛАХ

Хувийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудтай хамтран ажиллах загвар, санхүүжилт, чанарын хяналтын механизмыг сайжруулах олон улсын ба дотоодын зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулсан. Сангийн яамнаас 2024.12 30-ны өдөр 01/10803 тоот дугаартай албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн 2025 онд санхүүжилтийг хойшлуулах ажлын жагсаалтад багтсан тул хэрэгжилт удааширч цуцлагдсан.

## БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЛЭГ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ТУРШИХ

**Зорилго:** Хөдөлмөр эрхлэлтийн шинэлэг хөтөлбөрүүдийг сонгож турших

**Хөтөлбөрүүд:** Уг бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр, Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр гэсэн хоёр дэд хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлуулан хэрэгжүүлсэн.

**Зарцуулалт:** 2025 онд зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг сайжруулах хүрээнд сургагч багш бэлтгэх, сургалтын агуулга, хөтөлбөрийг шинэчлэх ажлыг хэрэгжүүлэхэд 18.5 сая төгрөгийн санхүүжилт, мөн И-Жоб системд нийлүүлсэн тоног төхөөрөмж, программ хангамж, лицензийн чанарын баталгааны төлбөрт 23.7 сая төгрөг, нийт 42.2 сая төгрөгийг зарцуулсан.

## ЗОРИЛТ 2.1. БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ

Төслийн хүрээнд 2024-2025 онд “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь бичил бизнес эрхлэгчдийн аж ахуй эрхлэх санхүүгийн болон санхүүгийн бус чадавхыг дээшлүүлэх замаар ажлын байр хадгалах, шинээр бий болгох, улмаар зорилтот хүн амын тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн: а) зээлийн өмнөх сургалт, б) жижиг зээл олгох болон в) зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ гэсэн үндсэн гурван арга хэмжээнээс бүрдсэн. Тодруулбал, зээл хүсэгчдийг бизнесийн санааг хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төсөл, төлөвлөгөө боловсруулах үр чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн зээлийн өмнөх сургалтад хамруулан холбогдох шаардлагын дагуу бизнесийн төслийг сонгон



шалгаруулж, жижиг зээл олгосны дараа төслөө амжилттай хэрэгжүүлэх, бизнесээ өргөжүүлэхэд чиглэгдсэн сургалт, менторинг үйлчилгээг үзүүлэх цаашлаад бизнесийн харилцаа холбоо тогтоох, туршлага судлах, нэмүү өртгийн сүлжээнд холбох зэрэг цогц арга хэмжээтэй.

**Үр шим хүртэгч:** (1) Хувиараа хөдөлмөр эрхлэгч, (2) Малчин, (3) Нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, (4) Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, (5) Гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн.

**Зарцуулалт:** Хөтөлбөрийн хүрээнд 2024 онд жижиг зээлийн санхүүжилтэд 13 тэрбум төгрөг, зээлийн өмнөх сургалтад 73 сая төгрөг, хөтөлбөрийг олон нийтэд сурталчлах ажилд 34 сая төгрөг, зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх сургагч багш нарыг бэлтгэх, сургалтын хөтөлбөр шинэчлэх ажилд 18,5 сая төгрөг, нийт 13.12 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Төслийн хүрээнд олгосон жижиг зээлийн эргэн төлөлтөөс үргэлжлүүлэн 2,3 тэрбум төгрөгийн зээлийг 50 бичил бизнес эрхлэгчид олгоод байна. Хөтөлбөрийн зарцуулалтын тайланг доорх хүснэгтэд харуулав.

### Хүснэгт 1. Жижиг зээл олголт

| № | Жижиг зээл                  | Хүний тоо  | Олгосон зээлийн хэмжээ /төг/ |
|---|-----------------------------|------------|------------------------------|
| 1 | Зээлийн үндсэн эх үүсвэрээс | 560        | 13,000,000,000               |
| 2 | Зээлийн эргэн төлөлтөөс     | 50         | 2,309,962,500                |
|   | <b>Нийт дүн</b>             | <b>610</b> | <b>15,309,962,500</b>        |

### Хүснэгт 2. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн үйл ажиллагааны зарцуулалт

| № | Арга хэмжээ                                                                                       | Хүний тоо    | Зарцуулалт /төг/   |
|---|---------------------------------------------------------------------------------------------------|--------------|--------------------|
| 1 | Зээлийн өмнөх сургалт                                                                             | 2,433        | 72,990,000         |
| 2 | Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх сургагч багш бэлтгэх, сургалтын хөтөлбөр шинэчлэх |              | 18,450,000         |
| 3 | Хөтөлбөрийн танилцуулга, материал бэлтгэх, олон нийтэд түгээх сурталчлах                          |              | 34,000,000         |
|   | <b>Нийт дүн</b>                                                                                   | <b>2,433</b> | <b>125,440,000</b> |

2.1.1. БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЖИЖИГ ЗЭЭЛ ОЛГОХ




2025 оны 06 сарын байдлаар хөтөлбөрийн хүрээнд нийт 610 (үүнээс 328 эмэгтэй) бичил бизнес эрхлэгчид 15,3 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. Үүнээс 2024 онд 13.4 тэрбум төгрөгийн зээлийг 570 бичил бизнес эрхлэгчид, 2025 онд зээлийн эргэн төлөлтөөс 1.9 тэрбум төгрөгийн зээлийг 40 бичил бизнес эрхлэгчид тус тус олгожээ. Олгосон зээлийн хэмжээг гэрээт банк тус бүрээр дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. Бичил зээл олголт, зээлийн эх үүсвэрээр, банкаар


2025 оны 06 сарын 30 -ний байдлаар

| №    | Банк        | Зээлийн үндсэн<br>эх үүсвэр<br>(төг) | Олгосон зээлийн хэмжээ 2024 он, өссөн дүнгээр |                |                 |
|------|-------------|--------------------------------------|-----------------------------------------------|----------------|-----------------|
|      |             |                                      | Нийт<br>(төг)                                 | Үүнээс:        |                 |
|      |             |                                      |                                               | Эх үүсвэрээс   | Эргэн төлөлтөөс |
| 1    | Хаан банк   | 6,500,000,000                        | 7,820,850,000                                 | 6,500,000,000  | 1,320,850,000   |
| 2    | Төрийн банк | 6,500,000,000                        | 7,489,112,500                                 | 6,500,000,000  | 989,112,500     |
| Нийт |             | 13,000,000,000                       | 15,309,962,500                                | 13,000,000,000 | 2,309,962,500   |

Зураг 1. Жижиг зээл авсан иргэд, насны бүлгээр



Зураг 2. Жижиг зээл авсан иргэд, хүйсээр



Зээл авсан иргэдийг насны бүлгээр авч үзвэл 36 хувь нь 35-44 насныхан, 36 хувь нь 45-59 насныхан, 18 хувь нь 25-34 насныхан байна. Харин хүйсийн хувьд 54 хувь нь эмэгтэй бизнес эрхлэгчид байна.






2. Борлуулалтаа нэмэгдүүлэх аргачлал, цахим сүлжээгээр бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулах арга барил эзэмших;
3. Анхан шатны санхүүгийн бүртгэлээ сайжруулах үр чадвар эзэмших;
4. Хувь хүний зорилго, бизнес эрхлэгчдэд хэрэгтэй зөөлөн үр чадвараа хөгжүүлэх, бизнесийн хэлбэр болон загвараа тодорхойлох.

Зээлийн дараах сургалтын жишиг хөтөлбөрийг сургалтын байгууллагуудад зориулан ГБХНХЯ-ны цахим хуудас <https://mlsp.gov.mn/content/detail/3684> болон бусад холбогдох сувгуудаар нийтэлсэн.

Мөн шинэчилсэн хөтөлбөрийн дагуу сургагч багш нарт зориулсан гарын авлагыг бэлтгэсэн. Гарын авлагыг 20 цагийн 4 нэгж модульд хамаарах 9 дэд сэдвийн хүрээнд шинэчлэн боловсруулж, сургагч багшид тавигдах шаардлага, арга зүй, хичээлийн өмнөх бэлтгэл, сургалтын өмнөх болон дараах үнэлгээ, тайлагнал зэрэг агуулгыг багтаасан.

### Зураг 5. Сургагч багш бэлтгэх сургалт



Сургагч багш бэлтгэх хоёр өдрийн онлайн сургалтыг 2025 оны 2 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулж, орон нутгийн бизнес хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага, сургалтын байгууллага болон бизнесийн хөгжлийн байгууллагуудын багш нарын чадавхыг бэхжүүлж, сургалтад хамрагдсан 41 сургагч багшид батламж олголоо.

### ЗОРИЛТ 2.2. УР ЧАДВАР ОЛГОХ ШИНЭЛЭГ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ

Хөтөлбөрийн зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага, хувь хүний хэрэгцээнд тулгуурлан ажилгүй, ажил хайж байгаа, ажил олоход хүндрэлтэй, мэргэшлийн түвшнээ ахиулах хүсэлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дэх эрэлттэй байгаа үр чадвар олгох сургалтад хамруулж, ажлын байраар хангахад чиглэсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт уг хөтөлбөрийг 2024-2025 онд хэрэгжүүлж байна.

**Үр шим хүртэгч:** (1) Ажил хайгч иргэн, (2) Ажилгүй иргэн, (3) Ажил олоход хүндрэлтэй иргэн, (4) Мэргэшлийн түвшнээ ахиулах хүсэлтэй иргэн, (5) Өмнөх мэдлэг, үр чадвараа үнэлүүлэх иргэн.

**Хөтөлбөрийн батлагдсан төсөв:** 1,948,000,000 төгрөг


**Санхүүжилт:** 1,745,408,000 төгрөг

**Зарцуулалт:** Хөтөлбөрийн үйл ажиллагааны зардалд 1,95 тэрбум төгрөг төлөвлөснөөс 1.75 тэрбум төгрөгийг 2024 онд зарцуулсан.

Хөтөлбөрийн бэлтгэл шатанд сургалтын бүртгэлийн системийг хөгжүүлж, хамрагдах хүсэлтэй иргэдийг цахим хэлбэрээр бүртгэн авсан. Улмаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн 20

мэргэжлийн чадамжийн нэгж, мэргэжлийн болон зөөлөн үр чадварын сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулан, сургагч багш нарыг бэлтгэх ажлыг зохион байгуулсан. Үүний дараа мэргэжлийн сургалтыг Улаанбаатар хот болон 7 аймагт амжилттай хэрэгжүүлж, нийт 725 иргэнийг сургалтад хамруулсан бөгөөд 677 нь сургалтаа амжилттай дүүргэн чадамжийн гэрчилгээ авсан. Түүнчлэн 298 иргэнийг мэргэшүүлэх сургалтад, 200 иргэн өмнөх мэдлэг, үр чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээнд хамруулж, гэрчилгээ олгосон.

**Зураг 6. Эрэлтэд нийцсэр үр чадвар олгох хөтөлбөрийн тойм мэдээлэл**



Сургалтын хамрах хүрээг эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл барилга, уул уурхай, хүнсний үйлдвэрлэлийн салбар зонхилж байна. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн насны бүлгээр харьцуулан үзэхэд 36-45 насныхан хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол нийт суралцагчдын 57 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байсан. Дэлгэрэнгүйг арга хэмжээ тус бүрээс үзнэ үү.




**Зураг 7. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байршил**



### 2.2.1. МЭРГЭЖЛИЙН БОЛОН ЗӨӨЛӨН УР ЧАДВАРЫН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА, ТОВХИМОЛ БОЛОВСРУУЛАХ, ХЭВЛЭХ, СУРГАГЧ БАГШ НАРЫГ БЭЛТГЭХ

Хөдөлмөр эрхлэлтэд шаардлагатай зөөлөн ур чадвар олгох сургалтын хөтөлбөр, Багшийн болон Суралцагчийн гарын авлагыг үндэсний болон олон улсын зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр боловсруулсан. Зөөлөн ур чадварын сургагч багш бэлтгэх сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Сургалтад нийт 48 багш, ажилтан амжилттай



хамрагдаж, "Зөөлөн ур чадварын сургагч" -ийн батламж олгосон. Гарын авлагыг хэвлэн 26 сургалтын байгууллага болон холбогдох байгууллагад хүргүүлсэн. Хичээлийн явцад нийт 185 багшийг багшийн гарын авлагаар, 1,085 суралцагчийг оролцогчийн гарын авлагаар хангасан.

### 2.2.2. АЖИЛГҮЙ БОЛОН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДЭД ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭРЭЛТТЭЙ БАЙГАА УР ЧАДВАРЫГ ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ


Хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн ур чадвар олгох сургалтад нийт 725 оролцогч суралцсанаас 676 суралцагч буюу 93 хувь нь амжилттай төгсөж, чадамжийн гэрчилгээ авсан байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 33 иргэн Өгөгдлийн сангийн ажилтан, Сүлжмэлийн үйлдвэрийн технологийн ажилтан, Гурил, гурилан бүтээгдэхүүний ажилтан, Цахилгаан мэргэжлээр амжилттай хамрагдаж, чадамжийн гэрчилгээ авсан байна.

**Зураг 8. Мэргэжлийн ур чадвар олгох сургалт, мэргэжлээр**



Мэргэжлийн үр чадвар олгох сургалтыг мэргэжлийн чиглэлээр харьцуулж үзэхэд хүнд машин механизмын оператор, гагнуурчин мэргэжлүүдээр хамгийн олон хүн суралцаж төгсжээ.

**Зураг 9. Мэргэжлийн үр чадвар олгох сургалтад хамрагдсан 725 иргэний ерөнхий мэдээлэл**



Мэргэжлийн үр чадвар олгох сургалтад 36-55 насны иргэд түлхүү хамрагдсан. Харин хүйсийн хувьд, 44 хувь буюу 319 эмэгтэй, 56 хувь буюу 406 эрэгтэй суралцагч сургалтад хамрагдсан байна. Судалгаанаас харахад, дээд боловсролтой 18.7 хувь буюу 136 иргэн, техникийн болон түсгай дунд мэргэжилтэй 12.5 хувь буюу 91 иргэн мэргэжлийн үр чадвар олгох сургалтад хамрагджээ. Энэ нь тухайн иргэд өмнө нь төдийлөн хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжил эзэмшээгүй байж болзошгүйг харуулж байна.

**Зураг 10. Мэргэжлийн үр чадвар олгох сургалтын явц**



### 2.2.3. МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ

Мэргэшүүлэх болон давтан сургалтыг 14 мэргэжлийн хүрээнд зохион байгуулж, нийт 298 мэргэжилтэй ажилтан хамрагдсан байна. Салбарын хэмжээнд мэргэжилтэй ажилтны эрэлтийг судлах, хөдөлмөрийн зах зээл ажил олгогчийн эрэлтэд нийцсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, салбарын багш, инженер техникийн ажилтан, хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшлийн үр чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар дундын түншлэлийг хөгжүүлэхтэй уялдсан үйл ажиллагааг гүйцэтгүүлэх чиг үүрэг бүхий мэргэжлийн зөвлөл/холбоод институтээс хүргүүлсэн чиглэлийн дагуу мэргэшүүлэх болон давтан сургалтыг хариуцан хамтран ажиллав.

#### Хөдөлмөр эрхлэлтийн байдал




Зураг 11. Мэргэшүүлэх сургалт, мэргэжлээр



Мэргэшүүлэх болон давтан сургалт зохион байгуулах ажлын хүрээнд 14 мэргэжлээр өөрийн болон оношлох үнэлгээний дэвтэр /II, III, IV, V түвшин/ боловсруулж 298 мэргэжилтэй ажилтны мэргэшлийн түвшин тогтоох үнэлгээг хийсэн. Мөн үнэлгээний багц төлөвлөгөө боловсруулж 298 мэргэжилтэй ажилтны төгсөлтийн үнэлгээг зохион байгуулсан.

Зураг 12. Мэргэшүүлэх болон давтан сургалтад хамрагдсан 298 иргэний ерөнхий мэдээлэл






Мэргэшүүлэх сургалтад 26-35 насны залуучууд түлхүү хамрагдсан байна. Харин хүйсийн хувьд, 30.6 хувь буюу 92 эмэгтэй сургалтад хамрагдаж, чадамжийн гэрчилгээ авч, ажлын байрандаа мэргэшлийн түвшнээ ахиулах боломжийг нээсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд, 76.3 буюу 229

иргэн ажлын байртай бөгөөд мэргэшлийн түвшнээ ахиулах хүсэлтэй тул уг сургалтад хамрагдсан. Үүнээс дүгнэхэд, мэргэшүүлэх сургалтаар ажлын байртай мэргэжилтэй албан хаагчдын мэргэшлийн түвшнийг ахиулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх боломжийг бий болгосныг илэрхийлж байна.

#### 2.2.4. ИРГЭДИЙН ӨМНӨХ УР ЧАДВАРЫГ ХҮЛЭЭГ ЗӨВШӨӨРӨХ ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ

ХНХСҮСИ нь иргэний өмнөх мэдлэг үр чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээг мэргэжлийн зөвлөл, холбоод, ажил олгогчийн төлөөлөл бүхий мэргэшсэн үнэлгээний ажилтнуудаас бүрдсэн үнэлгээ, баталгаажуулалтын багийг институтийн захирлын тушаалаар мэргэжил тус бүрээр байгуулж хамтран ажилласан. Хөндлөнгийн үнэлгээ баталгаажуулалтын баг нь удирдамжийн дагуу үнэлгээний орчныг бүрдүүлэн 200 иргэний өмнөх мэдлэг үр чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээг аргачлалын дагуу хийсэн. Иргэний өмнөх мэдлэг үр чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээнд хамрагдсан нийт 200 иргэнээс 200 иргэн “чадамжтай” үнэлэгдсэн.

**Зураг 13. Иргэний өмнөх мэдлэг үр чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээнд хамрагдсан 200 иргэний ерөнхий мэдээлэл**



**Зураг 14. Иргэний өмнөх мэдлэг үр чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ, мэргэжлээр**



Иргэний өмнөх мэдлэг үр чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ (RPL)-нд 36-45 насны иргэд түлхүү хамрагдсан. Харин хүйсийн хувьд, 35.5 буюу 71 эмэгтэй RPL үнэлгээнд хамрагдаж, боловсролын бичиг баримт буюу чадамжийн гэрчилгээ авсан. Боловсролын түвшний хувьд, бүрэн дунд боловсролтой иргэд 71.9 хувь буюу дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд дээд боловсролтой 17 иргэн өөрийн өмнөх мэдлэг үр чадвараа үнэлүүлэн чадамжийн гэрчилгээ авсан байна. Хөдөлмөр эрхлээгүй 30 иргэн уг үнэлгээнд амжилттай хамрагдаж, ажлын байранд орсон байна.

**Зураг 15. Иргэний өмнөх мэдлэг үр чадварыг хүлээн зөвшөөрөх**



## 2.2.5. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн /хуучин нэрээр ХНХСҮСИ/-ийн хүсэлт болон хөтөлбөрийн гүйцэтгэлд үндэслэн “Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх [C2-CS-2023-10]/03/53 дугаартай зөвлөхийн гэрээнд 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үлдэгдэл төсвийн хүрээнд нэмэлтээр дараах ажлуудыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

- 1.1. Зөөлөн үр чадварын сургалтын нөлөөллийн үнэлгээг хийж танилцуулах;
- 1.2. Хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн үр чадвар олгох сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах;
- 1.3. Багш, суралцагчийн гарын авлага болон судалгааны тайланг нэмэлтээр хэвлэх;
- 2.1. Компьютер, тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авах;
- 2.2. Салбарын албан хаагчдыг чадавхжуулах сургалтад хамруулах.

Одоогийн байдлаар Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгээс нэмэлт ажлын хүрээнд 2025 оны 5-6 дугаар сард дараах ажлуудыг гүйцэтгээд байна: 1) Зөөлөн


ур чадварын сургалтын нөлөөллийн үнэлгээг ажлын даалгавар болон асуулгыг ДБ-ны зөвлөхүүд, үндэсний зөвлөхүүд хамтран боловсруулж, судалгааг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна. 2) Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнд шаардлагатай байгаа мэдээллийн технологийн тоног төхөөрөмж худалдан авах тендерийг зохион байгуулж, 93 сая төгрөгийн худалдан авалт хийгдээд байна.

## ЗОРИЛТ 2.3. "И-ЖОБ" ПЛАТФОРМЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ, БЭХЖҮҮЛЭХ

### 2.3.1. И-ЖОБ ПЛАТФОРМЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Төслийн хүрээнд И-Жоб платформын баталгаат 18 сарын хугацаанд системийг нэвтрүүлэх явцад гарсан алдааг засварлах, засвар үйлчилгээ хийх, нэмэлт сайжруулалт хийхэд дэмжлэг үзүүлж ажилласан бөгөөд 2024 онд уг платформыг захиалагчид бүрэн хүлээлгэн өгсөн.

2025 оны 6 сарын байдлаар И-Жоб системд 65,402 сул ажлын байр бүртгэгдэж, 78,127 хүн ажилд зуучлагдсан мэдээтэй байна. И-Жоб системд 236,039 ажил хайгч, 26,695 ажил олгогч бүртгүүлсэн байна. И-Жоб системийг улсын хэмжээнд 800 хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний мэргэжилтнүүд өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж хэвшсэн байна.



Салбарын хүрээний их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийн лицензийг нийлүүлэх (анхдагч ба хоёрдогч үүлэн дэд бүтэц угсрах) болон eJob хэрэглэгчдэд шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамж нийлүүлэх худалдан авалтын техникийн тодорхойлолтыг боловсруулж, ГБХНХЯ 2025.02.13-нд баталсан. ДБ-ны холбогдох мэргэжилтнүүдтэй 3 удаагийн уулзалт хийн шийдвэрлэсний дагуу олон улсын тендерийн урилгыг 2025.03.12-нд өдөр тутмын хэвлэл, яам болон төслийн вэб хуудсаар зарласан. 2025.04.24-нд тендерийн материал хүлээн авч, үнэлгээ хийн шалгарсан байгууллагад ГБХНХЯ-ны ТНБД-ын 2025.06.17-ны өдрийн 03/1972 албан бичгээр гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлсэн. Гэрээ байгуулах шатандаа байна.

Төслийн хүрээнд 2022 оны 8 сард сард "Хай Теч Солушн" ХХК ба "Саммит Компьютер Технологи" ХХК-тай байгуулсан 1) И-Жоб системийн тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах; 2) И-Жоб системийн программ хангамж, лиценз нийлүүлэх 2 гэрээний чанарын баталгаат хугацаа (3 жил) дууссан тул үлдэгдэл 5 хувийн төлбөр 23.7 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээт байгууллагуудад шилжүүлсэн.

### **БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МОНИТОРИНГ, ДҮН ШИНЖИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ, ТӨСЛИЙН УДИРДЛАГАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ**

**Зорилго:** Энэ бүрэлдэхүүн хэсэг нь байгууллага болон хувь хэрэглэгчдийн ашиглах хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн хүрээ, чанар, хүртээмжийг сайжруулж, мэдээлэлд үндэслэн зөв шийдвэр гаргахад нь туслах зорилготой. Үүний зэрэгцээ төслийн удирдлага, хяналт шинжилгээ, үнэлгээнд дэмжлэг үзүүлэх бөгөөд дараах хоёр дэд бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ: (а) Хөдөлмөрийн зах зээлийн мониторинг, шинжилгээ, (б) Төслийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ).

**Үр шим хүртэгч:** Төрийн байгууллагууд, бодлого боловсруулагчид, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэгчид, салбарын судалгааны байгууллага, судлаачид, ажил олгогчид, олон нийт, зорилтот бүлгийн иргэд байна.

**Зарцуулалт:** Тайлант хугацаанд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлын 3 гэрээний төлбөрт 128.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Гэрээт ажлууд бүрэн хэрэгжиж дууссан судалгааны байгууллага, 1 хувь зөвлөхийн 2 гэрээний үлдэгдэл 99.0 сая төгрөгийн төлбөрийн санхүүжилт СЯ дээр хүлээгдэж байна.

#### **ЗОРИЛТ 3.1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ**

Энэ дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 2025 онд албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгаа хийн, төслийн хүрээнд хэрэгжүүлсэн сургалтын хөтөлбөрийн үнэлгээний арга зүйг шинээр туршин хэрэгжүүлж, YAMAT-08-ыг шинэчлэн сайжрууллаа.

##### **3.1.2. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР СУДАЛГАА ХИЙХ, БОДЛОГЫН СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ**

Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгааг АФИМ Монголиа ТББ гэрээний дагуу гүйцэтгэлээ. Судалгааны тайланд албан бус эдийн засаг болон хөдөлмөр эрхлэлтийг тодорхойлох арга зүй, нэр томъёоны тодорхойлолтыг боловсруулсан. Мөн албан бус хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээлэл болон бусад судалгааны үр дүнд үндэслэн статистик шинжилгээ хийж, тулгарч буй асуудлуудыг тодорхойлсон. Түүнчлэн судалгаагаар албан ба албан бус секторт хамаарах албан бус хөдөлмөр эрхлэлт, түүний зохицуулалт, хууль эрх зүйн орчин, албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээг хамруулан судалж, дүгнэлт зөвлөмж гаргасан.

##### **3.1.3. ЭРЭЛТЭД НИЙЦСЭН УР ЧАДВАР ОЛГОХ ШИНЭЛЭГ ХӨТӨЛБӨРТ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ**

Төслийн хувь зөвлөх нь Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөрийн (ЭНУЧОХ)-ийн нөлөөллийн үнэлгээний дизайн, стратегийг боловсруулж, үнэлгээний үйл явцад хяналт тавин ажилласан. Хөтөлбөрийн үнэлгээг Нийгмийн бодлого, хөгжил судалгааны хүрээлэн (НБХСХ) ТББ гэрээний дагуу 2024-2025 онд гүйцэтгэлээ. Үнэлгээний баг нь хөтөлбөрийн үр дүн болон хэрэгжилтийн явцад хийсэн процессын үнэлгээг суурь, дүнд шатны болон эцсийн судалгаанд үндэслэн цогц байдлаар гүйцэтгэсэн. Тайланд процессын болон үр дүнгийн үнэлгээний зөвлөмжийг боловсруулан оруулсан. Төслийн хувь зөвлөх үнэлгээний тайлан боловсруулахад мэргэжлийн санал, зөвлөмж өгч, сайжруулалт хийхэд дэмжлэг үзүүлсэн.



Үнэлгээний тайланг танилцуулах үүлзалт 2025 оны 5 дугаар сард ГБХНХЯ дээр зохион байгуулагдаж, уг үүлзалтаар үнэлгээний үр дүн, амжилттай хэрэгжсэн үйл ажиллагаа, сайжруулах шаардлагатай чиглэлүүд, мөн бодлогын түвшинд хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг хэлэлцсэн.

ЭНУЧОХ-ийг үнэлэхэд ашигласан арга зүй нь хөдөлмөрийн салбарт өмнө нь ашиглагдаж байгаагүй шинэ арга зүйд тулгуурласан үнэлгээ болсноороо онцлогтой байсан. Арга зүйг ХЭДС-аас зохион байгуулж байгаа сургалтын хөтөлбөр болон бусад төсөл хөтөлбөр арга хэмжээний үр нөлөөг үнэлэхэд ашиглах боломжтой болсон нь цаашид судалгаанд тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг илүү үр дүнтэй төлөвлөх, хэрэгжүүлэх боломж бүрдүүлнэ. Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний үр нөлөөг үнэлж, дараагийн төсөл хөтөлбөрийг үр дүнд суурилсан байдлаар санхүүжүүлэх нь салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог төлөвшүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулна.

### 3.1.4. YAMAT-д нэмэлт ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ШИНЭЧЛЭХ, YAMAT-08 СИСТЕМИЙГ САЙЖРУУЛАХ

YAMAT-08-ыг шинэчлэх болон системийн сайжруулалтын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэв:

1. Гэрээний хүрээнд "Би И Эн Си" ХХК нь YAMAT-08-д нэмж оруулсан 65 ажил мэргэжлийн ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийг боловсруулан, YAMAT-08-ын цахим системийн засвар, хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэлээ. Энэ хүрээнд суурь судалгаа хийж, олон улсын жишиг тодорхойлолт болон дотоодын хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн ажил, мэргэжлийн товч болон дэлгэрэнгүй тодорхойлолтыг боловсруулсан.

Мөн YAMAT-08 цахим системийн ашиглалт, хэрэглээг сайжруулах, үүсч буй алдааг засварлах, системд мэдээлэл оруулахад шаардлагатай талбар, дэлгэцүүдийг хөгжүүлэх зорилгоор нийт 9 үндсэн өөрчлөлтийг хийж гүйцэтгэсэн. Цахим хувилбарын нэмэлт хөгжүүлэлтийн хүрээнд шинээр хийгдсэн өөрчлөлтүүдийг ашиглах хэрэглэгчийн зааварчилгаа болон цаашид системийг хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай зөвлөмжийг боловсруулан ГБХНХЯ-д хүлээлгэн өгсөн.

2. Төсөл нь гадаад улс орнуудын ажил мэргэжлийн чиг хандлагын өөрчлөлтийн судалгаа, YAMAT-ийг шинэчлэх санал зөвлөмж боловсруулж, хүнд үйлдвэр, геологи, уул уурхай, мэдээлэл технологийн салбарын нийт 100 ажил, мэргэжлийн профайлыг боловсруулах ажлыг 2 зөвлөхөөр

гэрээний дагуу гүйцэтгүүлсэн. ГБХНХ-ын Сайдын 2025 оны А/79 тушаалаар 100 ажил мэргэжлийн лавлахыг YAMAT-08-д нэмж баталсан. Ажил олгогчид профайлыг ашиглан хүний нөөц төлөвлөх, ажлын байрны үүрэгт ажлуудыг тодорхойлох, ажилтнуудын үр чадвар, гүйцэтгэлийг үнэлэх зэрэг олон зорилгоор байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах боломж бүрдсэн. Салбарын түвшинд салбарын ажил мэргэжлийн түвшинг тодорхойлох, үр чадварын түвшинг тогтооход чухал ач холбогдолтой болов.



ЗОРИЛТ 3.2. ТӨСЛИЙН УДИРДЛАГА, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

3.2.1. ТӨСЛИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

ТХН төслийн мониторинг ба тайлагналтын ажлыг гүйцэтгэхэд ГБХНХЯ-д дэмжлэг үзүүлж ажиллалаа. ТХН төслийн бүх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд, үүнд чадавх бэхжүүлэх сургалт, судалгаа шинжилгээ, хяналтын ажлуудыг хариуцан хэрэгжүүлсэн бөгөөд мөн төслийн хөгжлийн зорилт, дунд хугацааны үзүүлэлтүүдийн үр дүнг хянаж ажилласан.

Төслийн хяналт шинжилгээ, санхүү, худалдан аваа ажиллагаа, байгаль орчны удирдлагын хүрээ ба үр дүнгийн хүрээний тайланг ТУХ, ГБХНХЯ, СЯ ба ДБ-нд тогтоосон хугацаанд тайлагнаж, ЗГ-ын гадаад зээл, тусламжийн төслүүдийн цахим мэдээллийн системд мэдээлж ажиллав.

Төслийн 2024 оны санхүүгийн тайланд олон улсын стандартын дагуу хөндлөнгийн аудит хийлгэж, санал зөвлөмжийг авч ажиллалаа. Төслийн нягтлан бодох бүртгэлийн бүх баримт бичгийг үнэн зөв хангалттай бүрдүүлж ажилласан. Аудиторын дүгнэлтэд төслийн хөрөнгийн удирдлага асуудалгүй, дотоод санхүүгийн удирдлагын хяналтын системд аливаа зөрчил, материалын алдаа гараагүй болохыг дурдсан.

3.2.2. ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАН СУРТАЛЧЛАХ

Төслийн хэвлэлийн зөвлөх нь төслийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд төслийн хэрэгжилтийн талаар улирлын тойм 1, төслийн үр дүнг танилцуулсан 2 видео, үр шим хүртэгчдийн оролцсон 5 цуврал ярилцлагыг бэлтгэн олон нийтэд хүргэв. Мөн төслийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой өдөр тутмын мэдээ, мэдээллийг төслийн вэбсайт болон сошиал медиа хуудсуудаар дамжуулан тогтмол цахимаар түгээж байна.



ажиллагчид болон 18,598 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг нэг сарын хугацаанд чөлөөлсөн. Ажиллагчид болон ажил олгогчдын НДШ-ийг түр хугацаанд чөлөөлж, тэтгэмж олгосон нь онцгой байдлын үед нийгмийн даатгалын санд үүсэх санхүүгийн дарамтыг бууруулахад дэмжлэг болсон.

## ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төслийн нийт өртөг нь 20.0 сая ам.доллар. Үүнийг Олон Улсын Хөгжлийн ассоциациас Монгол Улсын Засгийн газарт олгох зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн.

2020-2025 онд төслийн үйл ажиллагааны зардалд нийт 49.07 тэрбум төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нийт санхүүжилтийн 81%-тай тэнцэж байна. Төслийн 2020-2025 оны санхүүгийн гүйцэтгэл бүрэлдэхүүн хэсгээр дараах байдалтай байна.

### Хүснэгт . Төслийн санхүүгийн гүйцэтгэл, бүрэлдэхүүн хэсгээр (2020-2025)

| Бүрэлдэхүүн хэсэг   | Хуваарилалт<br>(төг)  | Зарцуулалт<br>(төг)   | Үлдэгдэл<br>(төг)     | Зарцуулалт<br>(%) |
|---------------------|-----------------------|-----------------------|-----------------------|-------------------|
| Бүрэлдэхүүн хэсэг 1 | 3,744,000,000         | 3,487,736,603         | 256,263,397           | 93%               |
| Бүрэлдэхүүн хэсэг 2 | 24,474,000,000        | 14,884,308,000        | 9,589,692,000         | 61%               |
| Бүрэлдэхүүн хэсэг 3 | 3,332,000,000         | 2,249,2615,545        | 1,082,384,455         | 68%               |
| Бүрэлдэхүүн хэсэг 4 | 28,450,000,000        | 28,450,000,000        | -                     | 100%              |
| <b>НИЙТ</b>         | <b>60,000,000,000</b> | <b>49,071,660,148</b> | <b>10,928,339,852</b> | <b>81%</b>        |

Төслийн Удирдах хорооны хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 11.7 тэрбум төгрөгийн төсвийг баталсан. Төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 57 арга хэмжээ тусгагдсан. Сангийн яамнаас 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/10803 тоот албан бичгээр ГБХНХЯ-д тус салбарт гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн 2025 оны санхүүжилтийг түр хойшлуулахтай холбоотой ажлын жагсаалтыг ирүүлсэн. Уг шийдвэрийн хүрээнд СЯ төслийн 37 арга хэмжээг хойшлуулж, ТХН, 19 арга хэмжээний 6.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг баталсан.

Төслийн 2025 оны үйл ажиллагааны зардалд нийт 917.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс тайлант хугацаанд гэрээт ажлуудын гүйцэтгэлийг үндэслэн 13 гүйцэтгэгчид нийт 344.4 төгрөгийн төлбөрийн санхүүжилтийг олгосон. Санхүүгийн зарцуулалтыг бүрэлдэхүүн хэсэг түс бүрээр доор дэлгэрэнгүй оруулав.

### Төслийн 2025 оны санхүүгийн зарцуулалт, бүрэлдэхүүн хэсгээр, үйл ажиллагаагаар

Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд 2025 онд нийт 1 аж ахуйн нэгж, байгууллага, 2 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажилласан. Гэрээт ажлуудын гүйцэтгэл, санхүүгийн анхан шатны баримтыг нягталж, гүйцэтгэлээр нийт 129.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээний мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулах C1-CS-2023-7-1 тоот гэрээний эхний төлбөр 34.0 сая төгрөгийг Ажил мэргэжил судлалын үндэсний хүрээлэн НҮТББ-д олгосон.
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудыг чадавхжуулах сургалтын материалыг видео болгон хөрвүүлэх C1-CS-2024-6 тоот гэрээний эхний төлбөр 59.0 сая төгрөгийг Майнд Вайд ХХК-д олгосон.

- Хөдөлмөр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаарх онлайн сургалтын модуль боловсруулах C1-CS-2023-6-1 тоот гэрээний эхний төлбөр 36.0 сая төгрөгийг Мэдлэгийн хотхон НҮТББ-д олгосон.

Салбарын удирдах ажилтнуудыг олон улсын хурал чуулганд оролцуулах томилолтын зардалд 299.4 сая төгрөгийг зарцуулсан. Үүнд:

- 2025 онд Швейцарын Холбооны Улсын Женев хотод зохион байгуулсан Олон Улсын Хөдөлмөрийн Бага хурлын ээлжит 113 дүгээр чуулганд ГБХНХЯ-ны удирдах ажилтнуудыг оролцуулах гадаад томилолтын зардалд 45,47 сая төгрөгийн төсөвт өртгөөр батлуулж, санхүүжилтийг олгосон.
- АНУ-ын Вашингтон хотод зохион байгуулсан Дэлхийн банкны 2025 оны хаврын чуулга уулзалтад оролцох 9 төлөөлөгчийн томилолтын зардлын 253,89 сая төгрөгийн төсвийг Сангийн яамаар батлуулж, санхүүжилтийг бүрэн олгосон.

Бүрэлдэхүүн хэсэг 2-ын хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд ХНХСҮСИ, 1 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажилласан. Гэрээт ажлуудын гүйцэтгэл, санхүүгийн анхан шатны баримтыг нягталж, гүйцэтгэлээр нийт 42.15 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

- Жижиг зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх сургагч багш нарыг бэлтгэх, сургалтын агуулга сайжруулах зорилгоор Хөгжлийн Шийдэл ТББ-тай C2-CS-2024-9 тоот гэрээг 18,45 сая төгрөгийн төсөв өртгөөр байгуулж, гэрээний төлбөр 18,45 сая төгрөгийг олгосон.
- И-Жоб системийн тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах ба И-Жоб системийн программ хангамж, лиценз нийлүүлэх 2 гэрээний чанарын баталгаат хугацаа (3 жил) дууссан тул үлдэгдэл 5 хувийн төлбөр 23.7 сая төгрөгийн санхүүжилтийг "Хай Теч Солушн" ХХК ба "Саммит Компьютер Технологи" ХХК-д шилжүүлсэн.

Бүрэлдэхүүн 3-ийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн мониторинг, дүн шинжилгээ, төслийн санхүүгийн аудит, төслийн мэдээлэл сурталчилгааны ажлын хүрээнд 1 судалгааны байгууллага, 2 аж ахуйн нэгж, байгууллага, 4 хувь зөвлөхтэй гэрээ байгуулан хамтран ажилласан. Гэрээт ажлуудын гүйцэтгэл, санхүүгийн анхан шатны баримтыг нягталж, гүйцэтгэлээр нийт 173.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

- Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгаа хийх C3-CS-2023-27-1 тоот гэрээний эхний төлбөр 38.7 сая төгрөгийг АФИМ Монголия ТББ-д олгосон.
- И-Жоб платформд шинээр нэмж оруулсан ажил мэргэжлүүдийн профайлыг боловсруулах C3-CS-2024-4 тоот гэрээний 2 дах төлбөр 53.9 сая төгрөгийг Би И Эн Си ХХК-д олгосон.
- Үндэсний ажил мэргэжлийн ангиалал тодорхойлох (YAMAT)-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх C3-CS-2024-15-01 тоот гэрээний төлбөр 25.2 сая төгрөгийг зөвлөх Т.Энхтуяа-д олгосон.
- Үндэсний ажил мэргэжлийн ангиалал тодорхойлох (YAMAT)-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх C3-CS-2024-15-02 тоот гэрээний төлбөр 10.8 сая төгрөгийг зөвлөх Д.Биндиряа-д олгосон.
- Бичил бизнес эрхлэгчдэд жижиг зээл олгоход дэмжлэг үзүүлэх C3-CS- 2023-32-1 тоот гэрээний төлбөр 5.6 сая төгрөгийг зөвлөх Ц.Дүгэрмаа-д олгосон.

- Төслийн мэдээлэл сурталчилгааны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх СЗ-СЗ-2024-12 тоот гэрээний төлбөр 27.0 сая төгрөгийг хэвлэлийн зөвлөх Б.Батзаяа-д олгосон.
- Төслийн 2024 оны санхүүгийн байдал, тайлан, төсвийн гүйцэтгэлд хөндлөнгийн аудит хийсэн "Ди Эй Би Жи" ХХК-д гэрээний төлбөр 12.0 сая төгрөгийг олгосон.

Гэрээт ажлууд бүрэн хэрэгжиж дууссан судалгааны байгууллага, 1 хувь зөвлөхийн 2 гэрээний үлдэгдэл 99.0 сая төгрөгийн төлбөрийн санхүүжилт СЯ дээр хүлээгдэж байна.

## ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**Төслийн гэрээний хэрэгжилт.** Төсөл 2020-2025 онд нийт 4.2 тэрбум төгрөгийн төсөв өртөг бүхий 28 гэрээг амжилттай хэрэгжүүлж дууссан байна. 2025 онд 9 гэрээ амжилттай хэрэгжиж дууссан бөгөөд 4 гэрээ дуусах шатанд явж байна.

**Худалдан авах ажиллагааны биелэлт.** Төсөл 2025 онд их өгөгдөлд суурилсан мэдээллийн системд зориулсан сервер, хадгалах төхөөрөмж, сүлжээний төхөөрөмж болон програм хангамжийн лицензүүд (үүлэн дэд бүтэц байгуулах) худалдан авах 1 үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Энэ нь салбарын мэдээллийн сан, системүүд, их өгөгдлийг үе шаттайгаар дундын үүлэн дэд бүтэц рүү шилжүүлж, цогц серверийн дэд бүтцийг байгуулахад ашиглагдах юм. Серверийн техникийн шаардлагын дагуу тендерийн баримт бичиг боловсруулан олон улсын нээлттэй тендер 2025 оны 03 дугаар сард зарлан, 2025 оны 04-06 сард 2 үе шатны үнэлгээг хийж, "Ай Ти Зон" ХХК компанийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан. Одоо гэрээ байгуулах шатандаа байна. Төслийн худалдан авалттай холбоотой мэдээллийг тухай бүр Дэлхийн банкны Худалдан авах ажиллагааны STEP системд байршуулж, мэдээллээр хангаж ажиллав.

## ДҮГНЭЛТ

2025 оны байдлаар төслийн үйл ажиллагааны зардалд нийт 49.07 тэрбум төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нийт санхүүжилтийн 81%-тай тэнцэж байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар төслийн 2025 онд батлагдсан төсвийн хүрээнд нийт 917.2 сая төгрөгийг зарцуулсан нь нийт төсвийн 13.4 хувийг эзэлж байна.

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2025 оны биелэлт 84%-ийн гүйцэтгэлтэй байна.

Төслийн 2025 оны батлагдсан санхүүжилтийн дээд хягаарын хүрээнд төслийн үлдсэн хугацаанд төлөвлөсөн бүх арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

Хянасан:

Ц.Байгалмаа (Төслийн зохицуулагч)

Боловсруулсан:

Ө.Цогзолмаа (Төслийн ХШҮ-ний ажилтан)